



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 2 (335)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай*
- *Засгийн газарт эрх олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2004 оны нэгдүгээр сарын 8

№ 2 (335)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

14.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай	(2003-12-18-ны хууль)	14
15.	БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарим зарлиг хүчингүй болсонд тооцох тухай	(2003-12-18-ны хууль)	15
16.	Хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай	(2003-12-18-ны хууль)	15
17.	Онцгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	(2003-12-26-ны хууль)	16
18.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	(2003-12-26-ны хууль)	16
19.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	(2003-12-26-ны хууль)	16
20.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	(2003-12-26-ны хууль)	16
21.	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай	(2003-12-26-ны хууль)	17
22.	Засгийн газарт эрх олгох тухай	(2003-12-31-ний хууль)	17

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

23.	Тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 59	17
24.	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 60	17
25.	Тогтоолын төслүүд буцаах тухай	Дугаар 61	18
26.	Төсөл буцаах тухай	Дугаар 62	18
27.	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 63	18

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

28.	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай	Дугаар 241	19
-----	--	------------	----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тогтоож, тэдгээрийг тэмдэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль тогтоомж

2.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,¹ Хөдөлмөрийн тухай хууль,² Үндэсний их баяр, наадмын тухай хууль³, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "нийтээр тэмдэглэх баярын өдөр" гэж улс орны хэмжээнд нийтээр амарч, баяр болгон тэмдэглэдэг өдрийг;

3.1.2. "нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр" гэж түүхэн болон тодорхой үйл явдалтай холбоотой, нийгмийн тодорхой давхаргыг хамарсан, бүх нийтээр тэмдэглэж заншсан өдрийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх

4 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын өдөр

4.1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр:

4.1.1. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 11, 12, 13;

4.1.2. Бүгд Найрамдах Улс тунхагласны баяр: 11 дүгээр сарын 26;

4.1.3. Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2;

4.1.4. Шинэ жил: 1 дүгээр сарын 1;

4.1.5. Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр: 3 дугаар сарын 8;

4.1.6. Хүүхдийн баяр: 6 дугаар сарын 1.

5 дугаар зүйл. Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр

5.1. Дор дурдсан тэмдэглэлт өдрийг Монгол Улсын хэмжээнд нийтээр тэмдэглэнэ:

5.1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр: 1 дүгээр сарын 13;

5.1.2. Зэвсэгт хүчний өдөр: 3 дугаар сарын 18;

5.1.3. Эрүүл мэндийг хамгаалах өдөр: 4 дүгээр сарын 7;

5.1.4. Оюуны өмчийг хамгаалах өдөр: 4 дүгээр сарын 26;

5.1.5. Гэр бүлийн өдөр: 5 дугаар сарын 15;

5.1.6. Залуучуудын өдөр: 8 дугаар сарын 25;

5.1.7. Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр: 9 дүгээр сарын 10;

5.1.8. Байгаль орчныг хамгаалах өдрүүд: 9 дүгээр сарын дөрөв дэх долоо хоног;

5.1.9. Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1;

5.1.10. Монгол Улсын Нийслэлийн өдөр: 10 дугаар сарын 29;

5.1.11. Хүний эрхийг хамгаалах өдөр: 12 дугаар сарын 10.

5.2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, энэ хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг Засгийн газар тогтооно.

6 дугаар зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх

6.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхэд төрийн ёслолын арга хэмжээг зохион байгуулж болно. Төрийн ёслолын журмыг Засгийн газар батална.

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Хөдөлмөрийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

³ Үндэсний их баяр, наадмын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.



6.2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг зардал багатай, хуульд өөрөөр заагаагүй бол нэг өдрөөс илүүгүй хугацаагаар тэмдэглэнэ.

болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулна.

6.3. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн үеэр улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх уралдаан, тэмцээний бай, шагнал нь Үндэсний их баяр наадмын бай шагналаас илүүгүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

8 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

7 дугаар зүйл. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

8.1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

8.1.1. энэ хуулийн 6.2, 6.3, 7.3-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох;

8.1.2. энэ хуулийн 6.2, 6.3-т заасныг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагыг 70000-250000 төгрөгөөр торгох.

7.1. Засгийн газар энэ хуулийн 5.2-т заасан баярын болон тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам баталж, төсөвт тусгагдсан зардлын гүйцэтгэлд хяналт тавина.

7.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 4, 5 дугаар зүйлд зааснаас бусад орон нутгийн хэмжээнд тэмдэглэх тэмдэглэлт өдрийг тогтоож, тэдгээрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам, зардлыг батална.

7.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төсөвт зардлыг хэтрүүлэхгүйгээр баярын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРИМ ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн "Баяр ёслолын болон тэмдэглэлт өдрийн тухай" 1985 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 137 дугаар зарлиг, "Нийгэм хангамжийн ажилтны өдөр тогтоох тухай" 1985 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 153 дугаар зарлиг, "Иргэний агаарын тээвэрчдийн өдөр тогтоох тухай" 1988 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 56 дугаар зарлиг, "Соёл урлагийн ажилтны өдөр тогтоох тухай" 1988 оны 6

дугаар сарын 23-ны өдрийн 97 дугаар зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1992 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан "Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн тухай" Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын "Боршоо" гэсний дараа "Арцсуурь" гэж; 2 дахь заалтын "Ханх" гэсний дараа "Ульхан майхан" гэж; 3 дахь заалтын "Эрэнцэв" гэсний дараа "Алтанбулаг" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Оросын Холбооны Улсаас импортолж байгаа цахилгаан эрчим хүчийг нэг жилийн хугацаагаар нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Оросын Холбооны Улсаас импортолж байгаа цахилгаан эрчим хүчийг нэг жилийн хугацаагаар гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацтай байгуулсан гэрээний дагуу "Тээвэр сэргээх төсөл"-ийн хүрээнд 1994-1995 онуудад нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээний зориулалтаар нийлүүлэгдсэн 44 автобус, 9 троллейбусыг гаалийн албан татвар /173.0 сая төгрөг/-аас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

хэрэгслийг импортоор оруулж ирсэн бол харьяалах татварын албанд тухайн жилдээ багтаан үлдсэн хугацаанд ногдох татварыг төлнө."

"1. Иргэн нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлнө. Хэрэв 6 дугаар сарын 1-нээс хойш авто тээврийн болон өөрөө явагч

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд импортлох улаан буудайн болон гурилын гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөн тогтоох эрхийг Засгийн газарт олгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцох тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай Монгол Улсын хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

4/ "Шинжлэх ухааны ажилтны өдөр бий болгох тухай" Монгол Улсын Их Хурлын 2001 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 101 дүгээр тогтоол;

1. Дор дурдсан тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцсугай:

5/ "Хөдөө аж ахуйн ажилтны өдөр бий болгох тухай" Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 13 дугаар тогтоол;

1/ "Нийслэлийн өдөр тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 56 дугаар тогтоол;

6/ "Байгаль орчныг хамгаалах өдрүүд бий болгох тухай" Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр тогтоол.

2/ "Залуучуудын өдөр бий болгох тухай" Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 29 дүгээр тогтоол;

2. Энэ тогтоолыг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3/ "Хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр бий болгох тухай" Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 33 дугаар тогтоолын 1 дэх заалт;

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

холбогдуулан 2004 оны 2 дугаар сарын 1-ний дотор дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль батлагдсантай



1/ нийтээр тэмдэглэхээс бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд зааснаас бусад олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон тэмдэглэлт өдрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох;

2/ нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх журам батлан мөрдүүлэх;

3/ Төрийн ёслолын журмыг шинэчлэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуультай уялдуулах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо / Д.Дэмбэрэл/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Тогтоолын төслүүд буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 2002 оны 12 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн

Оюуны өмчийг хамгаалах өдөр бий болгох тухай, 2003 оны 3 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Хоршоологчдын өдөр бий болгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг төсөл санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Монгол Улсын Их Хурлын ээлжит чуулганы нээлт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, нам, эвслийн бүлгийн төлөөлөгч үг хэлж болно." гэсэн одоогийн хуулийн заалтыг өөрчлөх

шаардлагагүй гэж үзсэн тул Улсын Их Хурлын гишүүн Л. Гүндалайн 2003 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн "Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай" хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, төсвийн алдагдлын тодорхой хэсгийг дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх зорилгоор 2004 оны төсвийн жилд

100.0 /нэг зуу/ хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, нийтэд санал болгон худалдахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээ явуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс (цаашид "Улсын комисс" гэх)-ын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Санхүү, эдийн засгийн сайд, Улсын комиссын дарга Ч.Улаанд даалгах нь:

а/төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон явуулж байхаар тогтоосугай;

б/төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг анхнаас нь чанартай зохион байгуулахын тулд 2003 оны 12 дугаар сард багтаан холбогдох журам, зааврыг шинэчлэн боловсруулан баталж улсын хэмжээгээр нэгдсэн журмаар мөрдүүлэхээр холбогдох байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авсугай;

в/Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын бүртгэл, тооллого, үнэлгээний ажлын нэгдсэн дүнг Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланд тусган Засгийн газраар хэлэлцүүлэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.5-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах арга хэмжээ авч ажилласугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг 2004 онд зохион байгуулахад шаардагдах 19.758.380 (арван есөн сая, долоон зуун тавин найман мянга, гурван зуун наян) төгрөгийг 2003 оны улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас гаргахыг зөвшөөрч, цаашид уг арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тооцож тусгаж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний ажлын бэлтгэлийг ханган аймаг, нийслэл, сум, дүүрэг болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссыг тус бүр томилон ажиллуулж, бүртгэл, тооллого, үнэлгээний ажлын дүнгийн тухай тайлан, мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр болон аймаг, нийслэлээр нэгтгэн жил бүрийн 2 дугаар сард багтаан Улсын комисст ирүүлэхийг сайд, агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

5. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, үнэлгээний жил бүрийн дүн мэдээгээр төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн санг бүрдүүлж ажиллахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого явуулах журам, заавар, маягтууд батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 29 дүгээр тогтоол, "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 183 дугаар тогтоолын 5 дахь зүйлийн "... тооллого явуулахад шаардагдах зардлыг тооцож ирэх оны төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд ..." гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын
Ерөнхий сайд**

Н.ЭНХБАЯР

**Санхүү, эдийн
засгийн сайд**

Ч.УЛААН



Засгийн газрын 2003 оны 241 дүгээр
тогтоолын хэвсрэлт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
БҮРТГЭЛ, ТООЛЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга	-Санхүү, эдийн засгийн сайд
Комиссын орлогч дарга	-Төрийн өмчийн хорооны дарга
Гишүүд:	-Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр);
	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
	-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Нийтгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
	-Авто замын газрын дарга.
Нарийн бичгийн дарга	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан ахлах референт.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1